

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Огноо: 2021.04.24

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2021/30 /СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ахлах аудитор Д.Цэрэндорж

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
	ТШЗ	41	36	3	2		36			
1	ТЕЗ	1	1				1			
	ДҮН	42	37	3	2		37			

Гурав. Аудитын үр дүн

3.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
A	1	2	3	4	5	6	7
1	ТШЗ	73	2,611.7	1,576.8	0.3	34.6	
2	ТЕЗ	3	224.5	224.5			
	ДҮН	76	1,836.2	1,801.3	0.3	34.6	

3.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулах:

Алдаа, зөрчилтэй асуудал 1

Шилэн дансны цахим хуудсанд төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээлэх 139 мэдээллээс 117 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд 447 мэдээллээс 415 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийн арилгах албан шаардлага хүргүүлэв.

Алдаа, зөрчилтэй асуудал 2

Харьяа байгууллагууд батлагдсан төсвийг зориулалтын дагуу бус, төсвийн эдийн засгийн ангилал гүйлгэн 111.1 сая төгрөг зарцуулсан байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төлөвлөлтийг сайжруулж, санхүүжилтийн зарчмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 3

Монгол Улсад Прокурорын байгууллага үүсч байгуулагдсаны 90 жилийн ойг тэмдэглэхэд 879.4 сая төгрөг зарцуулсан байна. Тухайлбал: Телевизийн 10 ангит уран сайхны кино бүтээхэд 203.6 сая, бэлэг дурсгалын зүйлд 185.0 сая, хүндэт тэмдэг, логонд 141.8 сая, ном бусад хэвлэлийн материалд 76.8 сая, баярын хүлээн авалтад 48.0 сая, баримтад кинонд 22.8 сая, спортын IV наадам тэмцээнд 45.1 сая, онол практикийн хурал, илтгэлийн уралдаанд 34.7 сая, урлагийн их наадамд 34.4 сая, түүхэн баримт, эх сурвалжуудыг бэлтгэх, видео танилцуулга, түүхчилсэн номын эх бэлтгэлийн ажилд 26.0 сая, шагнал урамшуулалд 20.9 сая, оролцогчдыг хүлээн авахад 19.8 сая, Ерөнхий прокуророор ажиллаж байсан хүмүүст хүндэтгэл үзүүлэх, гурван үеийн прокурорын уулзалтад 18.5 сая, гардений нээлтэд 2.1 сая төгрөгийг зарцуулсан ба анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиггүй зарцуулахгүй байх, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах зөвлөмж өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 4

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид олгосон нийт 341.6 сая төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Төсвийн төсөлд хүргүүлсэн урьдчилсан тооцоогоор олгосон, цалингийн тооцооллыг дахин хянаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 5

Харьяа байгууллагуудын дансны хуулга, цахим и-баримтыг тулган шалгахад тайлант хугацааны худалдан авалтын 113.4 сая төгрөгийн төлбөр цахим и-баримтгүй байна

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт /и баримт/-ыг бүрдүүлж, хэвших, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ
ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ
Б.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

2021.04.26 № 1311
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС, MNS6817-гийн дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A red rectangular stamp containing a handwritten signature in black ink. The signature appears to be 'Д.ЗАНДАНБАТ'.

Д.ЗАНДАНБАТ